# Виктори болон Христийн мэдээний агентлагаас И Жаерок пасторыг 2010 оны хамгийн нэр хүндтэй номлогчоор сонгон “Оны шилдэг Номлогч”оор өргөмжлөв.



Христийн алдарт сэтгүүл болох Ин Виктори (http://news.invictory.org/issue32289.html) хэмээх сэтгүүл ба Христийн мэдээний агентлаг (http://www.christiantelegraph.com/issue11870.html) 2011 оны Нэгдүгээр сарын 4 болон Нэгдүгээр сарын 15-нд 2010 оны ололт амжилт байгуулсан номлогч удирдагч нарыг шалгаруулан хамгийн нэр хүнд бүхий арван номлогчийг цохон дурьдав. Тэдгээр хүмүүс нь Христийн сургаалыг хэрхэн удирдан нөлөөлсөн нөлөөлөлөөрөө шалгарав. Ин Виктори хэвлэлийн ерөнхий редактор Сергеи Серженко, “2010 онд хийж гүйцэтгэсэн үүрэг амжилтууд ба нэр нь хэдий олон удаа хэвлэл мэдээлэлд дурдагдсанаар тус тус сонгогдсон билээ” хэмээв. Манмин Төв Сүмийн Тэргүүн пастор Доктор И Жаерок гуай нь 2010 оны шилдэг 10-н Христийн удирдагч нарын нэрд сонгогдсон ба “Оны Шилдэг Номлогч” өргөмжлөлийг авав. Мөн түүнчлэн, өнгөрсөн 2009 оны “Телевизийн Шилдэг Сургаал айлдагч”-р өргөмжлөлийг хүлээн авсан билээ. Өөр бусад 2010 оны нөлөө бүхий сүмийн удирдагч нарын нэрд шалгарагдсан хүмүүс нь:



Миссионер года

Джей Рок Ли

Пастор корейской мегацеркви «Манмин» не жалеет сил и ресурсов, чтобы принести пробуждение и Евангелие святости в самые дальние уголки земли. Израиль, Перу, Эстония, США, Индия, страны Африки — география служения церкви очень обширна. Пастор Ли уверен, что святость и Божья сила должны всегда сопровождать христиан.

Миссионер года Джей Рок Ли

▶ **Оны шилдэг авралын зар түгээгч Рейнхард Боннке:** Африкийн сая сая хүмүүсийг Их Эзэн Христ рүү удирдаж буй нэртэй авралын зар тараагч юм . Рейнхард нь хэдий 70 нас шахаж байгаа ч гэсэн интернэтийн нэгдсэн сайт болох Facebook -р дамжуулан маш олон хүмүүсийг Христ рүү удирдаж буй үлгэр жишээ удирдагч юм .

▶ **Оны Шилдэг Зохиолч Лиса Бевере:** Олон улсад алдартай итлгэгчээр тодорсон, үй олон номын зохиолч, ТВ нэвтрүүлэгүүдийн хөтлөгчийнхөө хувьд Лиса Бевере нь бүх дэлхий христэч эмэгтэйчүүдийг урамшуулан тэдний санал бодлыг нэгтгэн илүү сайн орчинг бүрдүүлдэг эмэгтэй удирдагч юм. 2010 онд Лиса Бевере нь “Эмэгтэйчүүдээ сэрэгтүн Өөрийн Ертөнцөө Өөрчил” хэмээх эмэгтэйчүүдэд зориулан ном бичсэн билээ.

▶ **Оны Шилдэг Номлогч И Жаерок:** Энэ пастор нь Христэч амьдрал хэрхэн байх ёстойг болон Ариун Сүнсний хүчээр бид ариун болдог хэмээн тунхагладаг хүн билээ. Тэрбээр Солонгос улсын нийслэл Сөүл хотод байрлах Манмин Төв Сүмийн тэргүүн пастор бөгөөд Израйль, Перу, Естони, Америкийн Нэгдсэн Улс, Энэтхэг болон Африкийн олон орнууд болон дэлхийн өнцөг булан бүрт Ариун сайн мэдээг тунхаглан хүн төрөлхтөний авралын төлөө амь бие хайрлалгүй зүтгэж ирсэн билээ.

▶ **Оны Шилдэг Дипломатч Рик Баррен:** Саддлебак сүмийн пастор нь интернетийн Твиттерийн хамгийн өргөн хэрэглэгчээр өргөмжлөгдсөн билээ. Рик Баррен нь улс төрийн нөлөө бүхий албан ажилтануудад авралын зар түгээдэг цөөхөн хэдэн пасторуудын нэг юм. 2010 онд тэрбээр Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч асан Жорж В. Буштэй сүм дээр нь ярилцлага хийсэн билээ.

▶ **Оны Шилдэг тусламжийн ажилтан Франклин Грахам:** Франклин Грахам нь Бурханы сургаалыг тараан түгээхийг өмнөх зорилгоо болгон ажилладаг ба эдийн засгийн болон эрүүл мэндийн асуудалтай байдаг хүмүүст тусалж байдаг энэрэнгүй үзэлтэй хүн билээ. Тэрбээр Самаритан хэмээх дэлхий дахинаа алдаршсан байгууллагын ерөнхийлөгч ба Билл Грахам Евангелийн Холбооны ерөнхийлөгчөөр тус тус ажилладаг билээ. Самаритан хэмээх байгууллага нь өнөөгийн байдлаар 100-аад орнуудад үйл ажиллагаагаа явуулсаар байгаа билээ.

▶ **Оны Шилдэг Пастор Пол Мелничук:** Украйны цагаач иргэний хүү болох Пол Мелничук нь олон улсын цар хүрээтэй болох Залбиралын Ордон хэмээх нэртэй сүмийг удирдан зохион байгуулдаг билээ. Хэдий либерал үзэл бодолтой байдаг боловч Пол нь Бурханы сургаал номлолыг чандлан сахин сурган тунхагладаг билээ. Залбиралын Ордон хэмээх сүм нь Христийн 50-иад үндэстнүүдийг холбон ажилладаг билээ.

▶ **Оны Шилдэг Удирдагч Жамес Давис:** Жамес Давис нь “Сая хүмүүсийн Сүлжээ Холбоо хэмээх нэртэй эвслийн үндэслэгчидийн нэг билээ. Тэрхүү эвсэлд нийт 350,000 орчим сүмүүд багтаж байдаг. Жамес нь авъяаслаг удирдагч ба тэрбээр бусад пасторуудыг удирдан холбож таван сая сүмүүдийг холбон ажиллаж нэг тэр бум хүмүүсийг Христэд авчрах зорилготой байдаг билээ.

▶ **Оны Шилдэг Үндэслэгч Марк Дрисколл: Вашингтон мужын Сиэтли хотын Марс Хилл Сүмийн пастор билээ. Тэрбээр сүмийг олон нийтэд нээлттэй болгон өөрчлөх үндэслэлийг бий болгосон юм ба тэрбээр шинэ арга барил байнга хэрэглэж байдаг билээ. Марс Хилл Сүм нь өөрийн итгэгчдийн интернет сүлжээг бий болгосон ба ингэснээрээ сүмийн гишүүд өөр хоорондоо харилцан холбоотой байцгаадаг билээ.**

▶ **Оны Шилдэг Нэвтрүүлэгч Жамес Добсон:** ‘Гэр Бүлээ Анхаарцгаая’ хэмээх гэр бүлийн үйл ажиллагааг гардан зохион байгуулдаг байгууллагын удирдагч ба 30 жилийн турш сүмийн үйл ажиллагааг зохион байгуулж байсныхаа дараа Жамес Добсон нь ‘Гэр Бүлийн Яриа’ сэдэвт радио хөтөлбөр зохион байгуулав. Тус хөтөлбөр гол зорилго нь гэр бүлийн тогтолцоог чандлан бататгах зорилготой ба Жамесын үзэл бодлоор гэр бүл нь нийгмийн хамгийн гол тулгуур хэмээн үздэг билээ.

▶ **Оны Шилдэг Стратегч Леонард Свеет:** Леонард Свеет нь Америкийн соёлын түүхч хүн ба нийгэмд гарч болзошгүй зүйлсийг урьдчилан харж дүгнэн бичиж байдаг зохиолч хүн билээ. Леонард нь маш олон сүмүүдэд урьдчилан тооцоололт гарган стратегийн агуу гайхамшигт нөлөөлөлүүдийг үзүүлж байдаг билээ.

Манмин Мэдээ
NO.10 2011 оны Гуравдугаар сарын 6

# Хөх тэнгэрийг чимэглэн буй гайхамшигт солонго

## Бурханы хайр ба амлалтыг бидэнд мэдрүүлсэн үзэсгэлэнт солонго



2011 оны Нэгдүгээр сарын 27-ны өдөр өглөөний 9:30-аас 10:30-ын хооронд (Чеолла-Нам-до Муан гүн Хэеже мён Чонжанли сан №153 )д орших Муан Амтат Усны хүрээлэнгийн дээр олон төрлийн гайхамшигт солонгуудын нийлбэр бий болсон билээ. [Ким Серем Nikon D80, Fisheye10.5мм, 1/500, f/11, ISO 200, 20110127_093433 хэлбэлзэлд зургыг авав]

2011 оны Нэгдүгээр сарын 27-ны өглөөний 9:30 минутын үед Муан Амтат усны хүрээлэнгийн орчим Ариун Библийн Египетээс Гарсан нь-н 15-р бүлэгт дурдсан шиг гайхамшигт хэлбэр дүрс бүхий солонго (цаг уур судлалын нэр томъёололоор ‘коронал феномена’) бий болов. Тэрхүү гайхамшигт солонго нь бүтэн цагын турш тэнгэрт үзэгдсэн ба олон давхар солонгууд байв. Нэг дэх солонго нь нарыг хүрээлсэн дугуй солонго бөгөөд хоёр хурц тод туяатай ба туяаныхаа үзүүрт алмааз шигтгээ мэт өнгөлөг харагдаж байв. Хоёр дахь солонго нь эхнийхээ солонготой холбогдсон ба тэр хоёр нь нийлээд нисэж байгаа тагтаа шувуу мэт хэлбэртэй байв. Нэгэн хагас дугуй хэлбэртэй солонго тэднийг хүрээлж байв.

Мөн түүнчлэн, сэвүүр хэлбэртэй нэгэн солонго тэрхүү хагас дугуй хэлбэртэй солонгын ойр үзэгдэж байв.

Ерөнхийдөө солонго нь агаар мандалд буй усны дусал болон цас мөсний талст биес нь нар гэрэлд ойж, хөндлөн хугарлын үр дүнд үүсдэг гэрлийн хэлбэр билээ. Мөн түүнчлэн, бид солонго нь Ариун Библид дурдсан шиг (Эхлэлийн 9:13-т болон Илчлэлтийн 4:3-д) Бурханы амлалтын илэрхийлэл болон гарч байдаг шиг Муан амтат усны хүрээлэнгийн орчимд татсан бидний харж буй энэ солонго нь Бурханы хайр ба амлалтын илэрхийлэл болох сүнс зүгийн солонго болохыг мэдэж болно.

Иймэрхүү солонго нь зөвхөн Манмин Төв Сүм дээр бус солонгосын орон нутаг дахь Манмины салбар сүмүүд дээр ч гэсэн, гадаад дахь нэгдсэн цуглааны үйл ажиллагаа болон пастор, номлогчдын семинар уулзалтууд, Гар алчуурын цуглаан зэрэг Бурханы баяр баясгалан болж таалалд нийцсэн арга хэмжээнүүдийн үеэр болон сайн мэдээ хүчтэй түгээгдэж буй газар гэх мэт олон газар байнга үзэгддэгийг харж болно.

Илчлэлтийн 4:3-д, “Залрагч нь хаш чулуу ба молор эрдэнэ мэт дүртэй ажээ. Сэнтийг нь маргад эрдэнэ мэт үзэгдэх солонго хүрээлжээ.” хэмээн дурдан хэлсэн байдаг. Хүмүүс бие биендээ бөгж солилцон бие биендээ амлалт болгон өгч байдаг шиг Бурхан ч бас сэнтийг нь хүрээлсэн солонгоороо амлалтын баталгаа болгон хүн төрөлхтөнд үзүүлж өгдөг билээ.

1998 оны Тавдугаар сарын 15-наас эхлэн гарсан Манмин Төв Сүмийн дээр нарыг тойрсон дугуй хэлбэрт солонго татснаас хойш тус сүмийн итгэгч гишүүд 14дэх жилдээ төрөл бүрийн гайхамшигт солонгыг маш олон удаа харсаар ирсэн билээ. 2000 оноос эхэлсэн гадаадын нэгдсэн их цуглааныг зохион явуулах багийн суусан онгоцыг тойрсон хоёр, гурав дөрвөн давхар солонго онгоцыг хүрээлэн гарсан байхыг харсан ба заримдаа шулуун, үелэн гарсан, тэгш хэмгүй болон



К хэлбэрт солонгууд үзэгддэг байлаа. Иймэрхүү сүнслэг зүгийн гайхамшигт солонгуудыг хараад итгэгч та бүхэн итгэлийн хувьд баттай зогсон сүнсний орон зайг улам сайн ойлгож Шинэ Иерусалимын тэмүүлэл дүүрэн байхыг хүсье!.

“Загалмайн Сайн Мэдээ” Цувралууд -(9)

# Есүс яагаад бидний Аврагч вэ?

## - Аврагч болох болзол (2) -

“Бид төлөвшсөн хүмүүсийн дунд мэргэн ухааныг ярьдаг. Ингэхдээ өнгөрөн одож буй энэ үеийн удирдагчдын ухааныг ч бус, харин нууц дотор буй Бурханы мэргэн ухааныг бид ярьдаг. Энэ нь бидний алдрын төлөө үеүдээс ч өмнө Бурханы урьдаас тогтоосон нуугдмал мэргэн ухаан мөн.” (1 Коринт 2:6-7).



Доктор И Жэй руг

Христэд итгэгч хүн үл итгэгч болон шашингүй хүмүүст бид Аврагч Есүс Христийн тусламжтайгаар авралыг хүлээн авах болно гэдгийг хэлэхэд ихэнхи хүмүүс хүлээж авдаггүй бөгөөд тэдний дундаас зарим хэсэг нь Христэд итгэдэг хүмүүсийг “өөрсдийгөө зөвт хэмээн боддог хүмүүс” хэмээн нэрлэцгээдэг. Тийм ч учраас бид яагаад Есүс Христ нь бидний аврагч болсон талаар бүх хүмүүст ойлгуулахын тулд тайлбарлаж өгөх хэрэгтэй.

Түрүүчийн дугаарт би, Газар Золих хуулийн дагуу (Левит 25:25) Аврагч болох болзлын нэгдэх нь болох “ Хүн байх ёстой” ба Есүс Эзэн Адамын үр удам болох хүн төрөлхтөнийг гэм нүглээс аврах “Ойрын хамаатан” хэрхэн болсон талаар, мөн Аврагч нь “Адамын үр удмын хүн биш байх ёстой” гэсэн хоёрдахь болзлын талаар дурдсан. Өнөөдөр, гурав ба дөрөв дэх болзлуудын талаар тайлбарлая .

### *1. Есүс, “Өстөн дайсан муу ёрын сүнсийг ялах хүчтэй байх ёстой” гэх гурав дахь болзлыг хангав*

Дайн тулааны үед олзлогдсон цэргүүдээ эргүүлэн аврахын тулд дайтах нь маш их хүч чадал авхаалж самбаа шаарддаг. Үүнтэй адил, атгаг муу сүнснүүдийн эрхшээлд орж, тэдний боол болсон хүн төрөлхтөнийг аврахын тулд сүнслэг хүч чадалтай байх хэрэгтэй. Ийм хүч нь сүнсний ертөнцийн хуулиар бол гэм нүгэлгүй үед хүч дагалддаг билээ. Гэрэл гийхэд харанхуй нь замхран алга болдог шиг гэм нүгэлгүй бөгөөд гэрлийн дотор төгс байдаг хүн нь харанхуйд орших атгаг сүнснүүд ба чөтгөрийг ялах хүчтэй байдаг билээ.

Гэм нүглийг нь угын буюу төрөлхийн гэм нүгэл, ба өөрөө үйлдсэн гэм нүгэл гэж 2 ангилдаг.

Угын гэм нүгэл нь Адамын хийсэн гэм нүгэл нь түүний үр удам болох хүн төрөлхтөнд өв залгамжлагдан ирснийг хэлэх ба өөрөө үйлдсэн гэм нүгэл гэдэг нь энэ дэлхийд хүмүүс төрөхөөс аваад өсөж бойжих явцдаа өөрсдийн үйлдсэн гэм нүглүүдийг хэлдэг. Хүмүүс амьдралынхаа туршид том жижиг олон гэм нүглийг үйлддэг. Хүнд гэм нүгэл үйлдсэн хүнийг л гэм нүгэлтэй гэх бус, хөнгөн гэм нүгэл үйлдсэн хүн ч гэмтэн биз дээ?(Иаков 2:10) Хүмүүс хүний зүрх сэтгэлд хэдий хорон муу санаа байсан ч гэсэн тэр хүн хорон муу бузар үйл хийхгүй бол л гэм нүгэлтэн биш хэмээн үзэж байдаг билээ. Гэвч сүнсний ертөнцийн хуулиар бол гэм нүглийг үйлдлээр үйлдээгүй ч гэсэн хүн хэрэв зүрх сэтгэлдээ гэм нүгэлт бодол агуулж байгаагаараа гэм нүгэлтэнд тооцогддог билээ (1 Иохан 3:15д “Ах дүүгээ үзэн яддаг нэгэн нь алуурчин мөн.” Матай 5:28д “Харин Би та нарт хэлье, эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм. ”)

Тиймээс гэм нүглийг сэтгэл зүрхэндээ болон үйлдлээр үйлдсэн хэн ч хүн хүн төрөлхтөнийг гэм нүглээс аврах боломжгүй юм. Нөгөө талаар, Адамын үр удам болох хүн төрөлхтөн нь нь төрөлхийн гэм нүгэлтэй төрдөг ба энэ дэлхийд амьдрах явцдаа ч бас гэм нүгэл үйлдэцгээж байдаг билээ. Есүс маань Адамын үр удмаас гаралтай биш ба Ариун Сүнсний хүчээр төрсөн билээ. Ингэснээрээ Есүс нь төрөхөөсөө авахуулан Бурханы Үг сургаалыг даган мөрдөж байсан ба төрөлхийн гэм нүгэлгүй бөгөөд энэ дэлхийд амьдарч байх хугацаандаа ч гэсэн ямар ч гэм нүгэл үйлдээгүй билээ (Еврей 7:26; 1 Петр 2:22).

Тиймээс, Есүс нь “ Нүглийн хөлс нь үхэл” (Ромын 6:23) хэмээн дурдсан шиг хүн төрөлхтөнийг хуулийн хараалаас ангижруулан муу ёрын сүнсний эрхшээлээс хангалттай чөлөөлөх хүч чадалтай билээ.Загалмайд цовдлогдон нас барлаа ч гэсэн үхлийн хүчийг устган дахин амилсан билээ. Есүсийн өмнө атгаг муу сүнснүүд болон сатан ч өвдөг сөгдөж, тэр ч байтугай бүх төрлийн өвчин, бактери, нян хүртэл дуулгавартай болдог билээ. Ариун Библид дээр үзвэл муу сүнсэнд эзэмдүүлэн зовж буй хүн Есүс Эзэний өмнө очвол, Есүс Эзэнээс тэр муу сүнсэнд хандан “Түүнээс гар” гэж тушаахад тэр муу сүнс дуулгавартай гарч, хараагүй, сонсголгүй, хэлгүй, суумгай, өвчтэй хүмүүст мөн гар хүргэхэд төгс эрүүл болон эдгэрч байлаа. Сүнсний ертөнцийн хуулийн дагуу энэхүү агуу гайхамшигт хүч чадал нь зөвхөн Есүст ч биш Бурханы Есүст итгэдэг хүмүүст ч хүртэл хангагдан өгөгддөг билээ.

Бурханыг хайрлан, Түүний үгээр амьдардаг хүмүүс нь ийм сүнсний ертөнцийн хүч чадлыг агуулдаг ба муу ёрын сүнс сатаныг Есүс Христийн нэр дээр хөөн зайлуулдаг ба тийнхүү тэрбээр ямар ч хүнд хүчир зүйлийг даван туулах чадалтай байдаг. Надад тийм тохиолдолууд олонтаа тохиолддог байлаа. Долоон жилийн турш өвчтэй байхдаа эмчилгээний мөнгө төлбөрөө хийж чадахгүй үе ч байв. Хэдий тийм байсан ч, Бурханыг өөрийн амьдралдаа хүлээн аван гэм нүглээ чин сэтгэлээсээ гэмшин бүхий л өвчнөөсөө эдгэрч, гэр бүлээрээ аврал хүртэн түүнээс хойш ганц ч удаа өвдөлгүй, эмнэлэгт ч очиж байгаагүй билээ. Зөвхөн Бурханы үгийн сургаалийн дагуу амьдарч, хараагүй, сонсголгүй, хэлгүй цусны хорт хавдар, ДОХ ба эдгэршгүй өвчтэй байсан хүмүүст залбирал хийн эдгээж, газын хорт хийнд хордсон хүмүүсийг эдгээх болон муу ёрын сүнсийг ч хөөн зайлуулсан билээ.

Хүн төрөлхтөний түүхэнд, Есүсээс өөр хэн ч Аврагчийн болзлыг хангах байхгүй билээ. Хүн төрөлхтөний сайн ба мэргэн ухаантай гэх Будда, Күнз болон Сократ хэмээх хүмүүс маань өөрсдийн эцэг эхээс төрсөн Адамын үр удмын хүмүүс бөгөөд бүгд төрөлхийн гэм нүгэлтэй Бурханы өмнө хэн нь ч ариунаар амьдарч чадаагүй билээ.

### *2. Есүс Амиа ч зориулах хайр байх ёстой хэмээх дөрөвдүгээр болзол Есүс Амиа ч зориулах хайр байх ёстой хэмээх дөрөвдүгээр болзол*

Нэгэн ах дүүсийн дунд дүү нь өрөө төлж чадахгүйгээсээ болж шийтгэгдэх болсон тохиолдолд түүний ах нь дүүгийнхээ өрийг төлөхөд шийтгүүлэхгүй байж болох билээ . Гэхдээ тэр ах нь хичнээн баян байлаа гээд дүүгээ хайрлах сэтгэлгүй бол ямар ч утга учиргүй байх билээ. Хэрэв ах нь дүүгээ хайрлавал , өөрөө асар их хохирол амслаа ч гэсэн дүүгийнхээ өрийг төлж өгөх билээ.

Газар Золих хуульд ч мөн адил ядуу хүн газраа худалдахад тэр хүний хамгийн ойрын хамаатан болох хүн нь баян байлаа гээд тэр ядуу хүнийг хайрлах сэтгэлээр түүнд туслан, түүнд газрыг буцааж авч өгье гэх үед л Газар золих хууль хэрэгждэг билээ . Үүнтэй адил Есүс хэдийгээр Аврагчын эхний гурван болзлыг хангасан ч гэсэн хүн төрөлхтөнийг гэм нүглээс нь аврах хайрын сэтгэл байхгүй бол хүн төрөлхтөнийг гэм нүглээс нь аврахгүй байх байсан билээ.

Аврагч нь болохын тулд гэм нүгэлтний төлөө үхлийн шийтгэл болон асар их золиос өвдөлт зовлонг туулах болдог бөгөөд адгийн жигшүүрт гэмт хэрэгтэн мэт янз бүрийн басамжлал доромжлолыг аван эцэст нь модон загалмайнд цовлогдон, цус ба усаа урсган үхэх ёстой юм. Дэлхий дээр гэм хэрэгтнүүдийг олон аргаар яллан шийтгэдэг бол , сүнсний ертөнцийн хуулиар гэм нүгэлт хүн төрөлхтөний гэм нүглээс нь аврахын тулд Есүс зөвхөн үхээд л гүйцэх юм биш сүнсний ертөнцийн хуулийн дагуу “Модонд өлгөгдөх ” ёстой бөгөөд “Цусаа урсган” нас барах ёстой юм.

Галат 3:13-д, “Христ бидний төлөө хараал болсноороо биднийг Хуулийн хараалаас зольсон юм. Учир нь “Модон дээр өлгөгдөгч хүн бүр хараагдсан юм”’ гэж бичигдсэн байдаг. Энд ‘хуулийн хараалаас зольсон нь’ хэмээн хэлж байгаа нь Ром 6:23-д хэлсэн шиг “Нүглийн хөлс бол үхэл” юм. Хуулийн дагуу үхэл ирсэн бөгөөд гэм нүгэлтэн хүмүүсийг аврахын тулд сүнсний ертөнцийн хуулийн дагуу Аврагч маань хараал хүртсэн хүмүүсийн өлгөгдөх ёстой модонд Өөрөө өмнөөс үүрч өлгөгдөх нь сүнсний ертөнцийн хуулийн заалт юм Тиймээс, Аврагч Их Эзэн маань модон загалмайн дээр хараагдан зүхэгдэн гэм нүгэлт хүмүүсийн төлөө золиослогдон зовлон зүдгүүрийг аван үхлийг амссан билээ.

“Цусаа урсган” нас барах ёстой гэсэн ч мөн адил билээ . Левит 17:14-д, “Махан биеийн амин гол зүйл нь цус юм” хэмээн дурдан бичсэн байдаг ба Еврей 9:22-д, “Хуулийн дагуу бараг бүх юм цусаар цэвэршүүлэгддэг бөгөөд цус урсгахгүйгээр ямар ч уучлал байхгүй ажээ.” Энд “цус” хэмээн хэлж байгаа нь сүнсний ухагдахуунаар “Амь”ийг дурдаж байгаа юм. Хүн төрөлхтөн нь гэм нүглээс болж мөнх амиа алдсан билээ. Мэдээж энэ газар амьд мэт амьдарч байгаа юм шиг боловч мөнхөд амьдрах жинхэнэ амиа алдсан байгаа билээ. Сүнсний ухагдахуунаар цус нь амь бөгөөд

Аврагч маань цусаа урсгаж байж, гэмтнүүд гэм нүглээсээ уучлагдаж мөнх амийг олноо гэсэн үг юм. Мэдээж хэн нэгэн модонд өлгөгдөн цусаа урсгалаа гээд хүн төрөхтөний гэм нүгэл уучлагдах боломжгүй юм. Энэ дээр тайлбарласан шиг хүний гэм нүглийг уучлах чадалтай цус нь огт гэм зэмгүй өө сэвгүй цус байх ёстой билээ.Тэгвэл ийм гэм нүгэлгүй хүн юуны учир ингэж бусад хүний төлөө өмнөөс нь аймшигтай хэрцгий алуулсан юм бол? Өөрийн аминаас илүү бусдыг хайрлаж, Өөрийгөө төгс золиослосон Есүс нь биднийг хайрлах хайраа харуулсан юм(Ром 5:7-8).

Христэд итгэгч ах эгч дүү нараа,

Бидний Бурханы хайр нь хэзээд хувиршгүй юм. Тэрээр Цорын Ганц Хүүгээ дуулгаваргүй маш олон хүүхдүүддээ хүртэл зориулсан юм . Есүсийг тамлан зовоон тарчилааж байсан цэрэг эрсүүдийг хүртэл, “Эцэг минь юу хийж байгаагаа үл мэдэх эдгээр хүмүүсийг өршөөгөөч” хэмээн тэднийг хайрлан залбирч байсан билээ.

Манмин Сүмийн Мэдээний энэ дугаарт хүн төрөлхтөний Аврагч болох болзлын тухай тайлбарлалаа. Эрхэм уншигч та цорын ганц Есүс л Бидний Аврагч юм гэдгийг мэдэж авлаа. Тиймээс та Есүс Христийг зүрх сэтгэлдээ хүлээн аван Түүний үг сургаалийнх дагуу амьдран мөнхийн авралыг хүртэхээс гадна бусад хүмүүсийг ч мөнхийн амьдралд ороход нь туслаарай хэмээн Их Эзэний нэрээр хүсэн ерөөе!

Mongolian
Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеүл,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин



# “Амьд Бурхантай уулзсанаас хойш эдгэрэл ба ерөөл миний амьдралд дүүрэн байна”

**МөнхТуяа итгэгч** (53 настай, Монгол Манмин Сүм)

2004 онд би өөр цуглаанд Эзэн Есүсийг хүлээн авсан хэдий ч тэр хугацаанд итгэлийн амьдралын жинхэнэ утга учрыг мэдэлгүй өнгөрч нүдээр харж байсан ч гэсэн жинхэнэ үнэнийг ухааралгүй цуглаан руу явмаар үедээ л явдаг байв. Библи болон итгэлийн амьдралын тухай олон ном уншсан боловч миний сэтгэл зүрх урьдын адил хоосон, хэвээрээ л байв. Тухайн үед би хаанаас ч зүрх сэтгэл хангалуун тайван байдлыг олж чаддаггүй байв.

Ийм байдлын хажуугаар элэгний С ангилал вирусын үрэвсэл мөн үе мөчний үрэвслийн улмаас бие өвддөг тул сэтгэл санаагаар их унадаг бөгөөд архи уух хүртэл зуршилтай байв. Миний 20 гаруй настай хүү маань буруу замаар явж эхлэхэд нь би санаа зовж Бурхан намайг хэзээ ч өршөөхгүй гэсэн айдас дотор өнгөрүүлж байлаа.



Ө. Мөнхтуяа итгэгч (голд нь) нөхөр, ээжийнхээ хамт инээмсэглэн зогсож байгаа нь

( Залбиралын өмнө ) ( Залбиралын дараа )



Эмнэлгийн Магадлагаа: Архаг элэгний С Ангилалын вируст үрэвсэл



Антиген-антибоди реакц: элэгний С Ангилалын үрэвслийн вирус илрээгүй



Элэгний Байдал: Маш Хүнд (Элэгний үйл ажиллагаа маш муу)



Элэгний Байдал: Хэвийн болсон (Элэгний үйл ажиллагаа сайжирсан)

### И Жае рок пасторын сургаалыг сонсож, Бурханы эрх мэдэлт хүч чадлын үйлсийг харсан нь

Тэгж байтал гайхамшигтай зүйл тохиолдсон юм. 2010 оны Гуравдугаар сард Монголын Манмин Сүмийн удирдагч Номлогч Батзоригын ээж нь намайг сүмд хүрч ирэхийг урив. Би И Жае рок пасторын сургаалыг дэлгэцээр дамжуулан сонсоод их ивээл Бурханы хайрыг мэдэрсэн билээ . И Жае рок пасторын сургаал болон ном хэвлэлээр дамжуулан урьд өмнө сонсож харж байгаагүй зүйлүүдийг мөн Библийн ойлгогдохгүй хэсгүүдийг маш ойлгомжтой сайтар тайлбарладаг тул ойлгоход амар байсан бөгөөд урьд өмнө миний сонсож байсан ямар ч номлогч нараас илүүтэйгээр тайлбарлан хэлдэг байсан учраас юм.

Гэвч ажил төрөл болон гэр бүлийн элдэв асуудлуудаас болон би сард хоёр л удаа цуглаанд очдог байв. Өнгөрсөн 9-р сарын сүүлээс эхлэн миний элэгний С ангилал вирусын үрэвсэл хүндрэн гэдэс маань хөөн томорч бүх бие минь хавдан ямар ч хүчгүй болсон билээ. Эмч нар үзээд маш түргэн хугацаанд эмчилгээнд орж эмчлүүлэхгүй бол элэгний хорт хавдар болон өөрчлөгдөх хүнд үе дээрээ байна гэж анхааруулав. Гэхдээ би тэргүүн пасторын эрх мэдэлт хүч чадалт залбирлаар дамжуулан эдгэрсэн олон хүмүүсийн гэрчлэлүүдийг харж сонсож байсан тул хагалгаа хийлгэхгүйгээр эдгэрэхийг чин сэтгэлээсээ хүсэж байсан юм.

### Итгэлээрээ залбиран чин сэтгэлээсээ гэм нүглээ гэмшсэнээр элэгний Сангилалын вирусын үрэвсэл өвчнөөсөө эдгэрсэн нь

2010 оны Аравдугаар сарын 11-ны өдрөөс эхлэн “Онцгой Даниелын Залбиралын Цаг” эхэлсэн юм. Би ч хүсэн тэмүүлэх зүрх сэтгэл дотор төлөвлөн залбирч Эзэний ариун өдрийг төгс сахиж эхлэв. Ялангуяа Тэргүүн пасторын сургаал дунд итгэгчдээ гэм нүгэл үйлдэхгүй байхыг нулимсаараа захиж байгааг санан чин сэтгэлээсээ гэмшсэн билээ.

Их Эзэнийг өөрийнхөө амьдралд хүлээн аваад 7-н жил болсон гэсэн итгэлийн амьдралаар зөв боловсон амьдраагүй ба харин ч дэлхий ертөнцийн амьдралд улам их татагдан архи тамхитай нөхөрлөн амьдарч байснаа чин сэтгэлээсээ гэм нүглээ гэмшихэд бүх бие минь Ариун Сүнсний галаар дүүрсэн юм.Түүний дараа гэдэсний хөөж хавдсан байсан хавдар нь алга болж биеийн байдал сайжирч байгааг мэдэрсэн юм.

2010 оны Аравдугаар сарын 18-нд би эмнэлэг рүү шинжилгээ хийлгэхээр очсон ба шинжилгээний хариу нь өвчний үүсгэгч элэгний С ангилалын вирус нь устаж элэгний үйл ажиллагаа хэвийн болон сэргэсэн байв. Эмч, С ангилалын шар өвчин нь эдгэрэшгүй өвчлөлтүүдийн нэг билээ. Элэгний С ангилалын вирус нь устаж бүрэн эдгэрсэн нь үнэхээр гайхамшигтай байна хэмээн надад хэлэв. Мөн түүнчлэн, 3 жилийн турш үе мөчний өвчлөлттэй байсан ба зүрхний сул үйл ажиллагаа маань тус тус маш сайжран түүнээс хойш би эмнэлэг рүү явах ямар ч хэрэггүй болов.

### Гэр бүлээрээ авралыг хүртэн бид бүгдээрээ аз жаргал баяр хөөрөөр дүүрэн байна.

Үүний дараа маш олон гайхамшигт зүйлс миний гэр бүлд тохиолдов. Миний бие эдгэрэн илааршсанд нөхрийн маань сэтгэл зүрх нь хөдлөн сүмд явж эхлэв. Нөхөр маань нурууны диск өвчтэй байсан ба тэр өвчнөөсөө эдгэрэн зөв шулуун алхах боломжтой болов.

Хүү маань ч аавыгаа уучлан би ч хадам ээжтэй эв нэгдэлтэй болсон нь үнэхээр аз жаргалтай байна.

Урьд нь би хадам ээжийгээ сэтгэлдээ уучлалгүй байсан ба үргэлж үзэн ядалт дотор хэцүүхэн амьдарч байлаа. Яагаад би хадам ээжийгээ үзэн яддаг байсан бэ гэвэл тэр намайг төрсөн эцэгтэй минь уулзуулдаггүй бүр нас барахад нь хүртэл уулзуулахгүй хорьдог учраас тэгдэг байлаа. Миний үзэн ядалт маань хадам ээжийгээ өвдөх үед нь надад баяр, баяр жаргалтай үед нь надад гуниг уйтгарыг авчирдаг байлаа. Гэтэл нэгэн өдөр би залбирал үйлдэж байтал Ариун Сүнс надад хадам ээжийгээ уучил гэхийг сонсов. Тийнхүү би хадам ээжийгээ чин сэтгэлээсээ уучилсан. Одоо гэр бүлийнхэн маань бүгд амар амгалан болцгоов.

Би зөвхөн өвчнөөсөө эдгэрсэн төдийгүй миний үзэн ядалтаар зовж байсан зүрх сэтгэлийн өвчнөөсөө хүртэл чөлөөлөгдөн амьдралдаа анх удаа 3 өдрийн мацаг барилт болон залбирлийг хийсэн билээ. Одоо би ариун төрх байдалтайгаар Бурханыг хайрлан үйлчлэхийг хүсэж байна.Үхлийн босгон дээрээс татаж аварч өгсөн Бурхан Аавдаа болон Эзэндээ бүхий л талархал ба алдрыг өргөн, үзэсгэлэнт сайхан зүрхтэй болохын тулд ариун сайн мэдээгээр удирдаж буй Тэргүүн пастортаа чин сэтгэлээсээ талархаж байна.

## “Цаг хугацаа орон зай үл хамаарах эрх мэдэлт хүчит залбиралаар Шүлхий өвчин халдсангүй”

2010 оны Арванхоёрдугаар сард Шүлхий өвчин Гуеонгбук аймгийн Андонг хотын ойр хавьцаанаас үүдэн Гуеонг-ги аймгаар дайран Ганвонду аймгийн Чунчеон хотод хүртэл тархан гарав., Чунчёон хот Нам Мён хороо Гажунг -Ри, -д манай сүмийн хэд хэдэн гишүүд ойр хавийн газруудад мал аж ахуй эрхэлцгээдэг юм .

Сүмд үйлчлэгч Юү Хее гюун(эрэгтэй 45 нас ) 12 толгой үхэр малтай ба Гажунг-Ри 146 хэмээх газар мал аж ахуйгаа эрхэлдэг байсан ба Нам-Мён хороонд Со Куёон сук итгэгч ( эрэгтэй 67нас) 70 толгой сүүн фирмийн үнээнүүд малладаг байв. Со Куёон сук итгэгч И Жаерок пасторын өвчтөний төлөөх залбирлын ЦХС (Цахим Хариултын Систем) рүү хандан залбирал хүртэн Муаны амтат уснаас малдаа аваачин ундны усанд нь хийн уулгав.

Арванхоёрдугаар сарын 25-нд, би И Жае рок тэргүүн пастор тай уулзсан ба түүнд би шүлхий өвчний халдвар нилээд газар авч Чунчёон хотод тархан гарсан тухай дурдан хэлэв. Тэрбээр Есүс Христийн нэр дээр итгэдэг хүмүүст тэрхүү шүлхий өвчин нь тусахгүй байх болно хэмээн айлдсан бөгөөд цаг хугацаа орон зай үл хамаарах эрх мэдэлт хүчит залбирал хүртлээ. Би зурагтаар мэдээ үзэж байхдаа тэрхүү халдварт өвчин нь манай сүмийн гишүүдийн амьдардаг газраар тархалгүй өнгөрсөнг олж мэдээд маш их сэтгэл хөдлөн баярлав

Магадгүй ганц л үхэр шүлхий өвчнөөр өвчилбөл тархалтыг зогсоохын тулд газрын 500 метр орчим хавийн малуудыг устган шатаан газарт булдаг билээ. Тиймд биднийг шүлхий өвчнөөс хамгаалж өгсөн Бурхандаа талархлыг өргөе! Залбирал хийж өгсөн тэргүүн пастортаа талархснаа илэрхийлье !

Халлелуяа!



Ким Донхеон Пастор
(Чунчеон Манмин Сүм)

Шүлхий өвчин нь үхэр, хонь ямаа, гахай тэжээвэр мал амьтанд хурц хэлбэрээр халддаг вирусийн төрлийн өвчин юм.

## Мөргөлийн цаг

| Мөргөл | Цаг |
|---|---|
| Их мөргөл | Ням гариг 10: 30 |
| Үдээс хойших мөргөл | Ням гариг 13: 40 |
| 3-дахь өдрийн мөргөл | 3 дахь өдөр 18: 00 |
| 5-дахь өдрийн мөргөл | 5 дахь өдөр 22: 00 |
| Хүүхдийн мөргөл | ням гариг 10: 30 |
| Сурагч залуучуудын мөргөл | Хагас сайн өдөр 16: 30 |

## Залбирлын цаг

| Ангилал | Цаг | Удирдагч |
|---|---|---|
| Даниел үүрийн залбирал | Даваа- баасан 05: 00- 06: 00 | Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч) |
| Даниел өдрийн залбирал | Даваа- баасан 09: 00- 10: 00 | П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч) |
| Даниел оройн залбирал | Өдөр бүр 18: 30- 20: 00 | П. Батзориг (Чуулганы хариуцагч) |




Хаяг: Баянзүрх дүүрэг,
13-р хороолол 6-р хороо,
ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637
чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773
www.manmin.org
www.manmintv.org